

**ХАМБА НОМУН ХАН ЛУВСАНДАНЗАНЖАНЦАНГИЙН  
“УВДИСТ РАШААНЫ ДУСАЛ” БҮТЭЭЛ ДЭХ НЭМЭР ЭМ  
ТАВИХ ЁСЫГ ШИНЖЛЭХҮЙ**

*М.Хастана<sup>1</sup>, Пунцагдаржа<sup>2</sup>, Б.Сумъяацэрэн<sup>3</sup>, Х.Улаан-Од<sup>4</sup>, Ш.Болд<sup>5</sup>*

*<sup>1,4,5</sup>“Ач” Анагаах ухааны их сургууль,*

*<sup>2</sup>БНХАУ, Нагчү Төвөд эмнэлгийн хороо,*

*<sup>3</sup>Эм зүйн шинжлэх ухааны их сургууль,*

*ulaanod@ach.edu.mn, 95331174*

**ANALYZING ADDITIONAL METHODS OF THE PRESCRIPTION  
IN THE “MAN NGAG BDUD RTSI ZEGS MA”  
WRITTEN BY KHAMBA NOMUN KHAN  
LUVSANDANZANJANTSAN**

*Khastana M<sup>1</sup>, Pingcuodajie<sup>2</sup>, Sumiyatseren B<sup>3</sup>, Ulaan-Od H<sup>4</sup>, Bold Sh<sup>5</sup>*

*<sup>1,4,5</sup>“ACH” Medical University,*

*<sup>2</sup>Na qu Men tsee-kang, China,*

*<sup>3</sup>Mongolian University of Pharmaceutical Sciences,*

*ulaanod@ach.edu.mn, 95331174*

**Abstract**

Mongolian traditional medicine is an enormous knowledge that has been battling with long term diseases of Mongolian ancestors by gaining experience, analyzing and learning from foreign medicinal theory and practice for 5000 years. Throughout this long historic evolution Mongolian scholars have published many writings about diagnosis, treatment, medicines and ingredients and among these arised Mongolian traditional medicine theory and practice.

The development basis of XXI century traditional medicine are the books and writings of previous doctors, scientists' knowledge and search through them in depth about practice, medicine especially ingredients and their correlation backgrounds are essential.

**Purpose**

Analyzing additional methods of the prescription included in the “man ngag bdud rtsi zegs ma” written by Khamba Nomun Khan Luvsandanzanjantsan.

**Methods**

Methods of check list, textual analysis for ancient books and analysis and synthesis were used in the study.

**Conclusion**

There are 47 prescription for the addition medicine included in the “man ngag bdud rtsi zegs ma” written by Khamba Nomun Khan Luvsandanzanjantsan. We classified them into 4 categories as supporting medicine, ruling medicine, changed medicine and dominant medicine.

The supporting medicines were chosen by doctors' knowledge and practice. Ruling medicine ingredients are used to elevate the effects on the cause, nature and symptoms of the disease, changed medicine ingredients are used to treat three humors's disorders and dominant medicine ingredients are used to treat complications.

**Keywords:** additional methods, prescription, Khamba Nomun Khan

## Үндэслэл

Монголын уламжлалт анагаах ухаан бол монголчуудын өвөг дээдсийн өвчин эмгэгтэй урт хугацааны турш тэмцэж ирсэн, туршлага суусан, алдаа оноогоо дүгнэсэн, бусад улс үндэстний анагаах ухааны онол, практикийг нэгтгэн дүгнэж өөриймсүүлж авсан 5000 жилийг туулж ирсэн анагаан эдгэрүүлэх, өвчнөөс сэргийлэх мэдлэгийн цогц сан юм<sup>1</sup>. Энэхүү урт хугацааны түүхэн хөгжлийн явцад монгол эрдэмтэн мэргэд оношилгоо, эмчилгээ болон эм, найрлагын салбарыг багтаасан олон арван зохиол бүтээлийг туурвиж, эдгээр бүхнээс Монгол анагаах ухааны онол, эмчилгээний арга туршлага бүрэлдэн гарсан гэж хэлж болно.

XXI зууны уламжлалт анагаах ухааны хөгжлийн үндэс нь өмнөх үеийн эмч, эрдэмтдийн бүтээн туурвисан анагаах ухааны хуучин ном, судрыг уншиж судлах, уг номуудад байгаа шинжлэх ухааны үндэстэй ойлголтыг гүнзгийрүүлэн ухаарах, эмч, маарамбуудын гарын авлага, увдисын гүн утгыг онож ойлгох, тэр дундаа эмийн жорын бүтэц бүрэлдхүүний нарийн холбоог зөв ухаарах, далд утгыг тодруулах асуудал уламжлалт анагаах ухааны хөгжилд чухал ач холбогдолтой юм.

## Зорилго

Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн “Увдист рашааны дусал” бүтээл дэх эм нэмэрлэх ёсыг шинжлэх.

## Зорилт

1. Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн “Увдист рашааны дусал” бүтээл дэх нэмэр эмтэй жоруудыг түүвэрлэн ангилах.
2. Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн “Увдист рашааны дусал” бүтээл дэх нэмэр эм тавих ёсонд шинжилгээ хийх.

## Судалгааны арга

1. Магадлан жагсаах арга

Бид магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргаар “Увдист рашааны дусал” бүтээл дэх нэмэр эмтэй жоруудыг түүвэрлэн төрөлжүүлэн жагсааж, тэдгээрийн ангилалыг тодруулав.

2. Эх бичиг, сурвалж бичгийн судлалын арга

Бид судалгаандаа “Увдист рашааны дусал” бүтээл дэх нэмэр эмтэй жоруудыг бусад эх сурвалж зохиолууд дахь нэмэр эм тависан жоруудтай харьцуулалт хийж, тухайн бүтээл дэх жоруудын нэмэр эм тавих ёс, онцлогийг тодруулхад энэхүү аргыг ашиглав.

3. Анализ, синтезийн арга

Анализ синтезийн арга нь судалж буй материалаа хэд хэдэн хэсэгт ангилж, задлан шинжлээд задалсан хэсгийг эргээд оновчтой байдлаар холбон нийлүүлэх үйлдэл юм. Бид судалгаандаа “Увдист рашааны дусал” бүтээл дэх нэмэр эмүүдыг үндсэн жор болон тухайн анагаах өвчинтэй нь холбон задлан шинжилхэд энэхүү аргыг ашиглав.

## Судалгааны үр дүн

Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн “Увдист рашааны дусал” бүтээлд<sup>2</sup> нэмэр эм тавиж хэрэглэсэн жор нийт 47 байна. Эдгээр жорууд дэх нэмэр эмүүдийг дараах 4 төрөлд ангилав.

### 1. Хачир эм (ᠬᠠᠴᠢᠷᠡᠮ)

Хачир эм хэрэглэсэн жор 10 байна. Үүнд: Өвсөн эм-11 дээр хорсны навч нэмбээс хий халуунаас бусад халуун өвчин бүхэнд машид тустай Гончогжав эмчийн ёс. Сэма-4-ийн тан дээр халуунаар шээс хаагдхад шунх, хүйтнээр шээс хаагдхад хэл цоргигч давсыг нэмэх нь гүн увдис. Нохойн хошууны цэцэг, цагаан банжин, чихэр өвс 3-ыг ширгээсэн шүүсэн дээр жуган, чихэр өвс хачирлаваас халуунаар дуу хаагдхыг дарах. Лиш-6 дээр царван нэмбээс дуу хаагдхыг анагаах. Лалапүд *Cnidium monnieri*(L.)cuss.<sup>3</sup> дээр халуунаар хоолны дуршил хаагдхад жуган дэжид, хүйтгээр хоолны дуршил хаагдхад 3 халууныг хачирлах. Руда-6 дээр пүрнаг *Artemisia santolinifolia* ex Bess Turcz<sup>4</sup>, хүдрийн заар нэмбээс цанх өвчнийг анагаах. Шижэд-6 дээр луувангийн үнс нэмбээс хир хаагдхыг анагаах. Хязаалан хонины толгойн шөл дээр агар-8, гавал-3-ын тан хачирлаваас толгойн бадган хий өвчийг анагаах зэрэг жорууд байна.

Хачир эмийг мэргэдийн гүн увдис, эмчийн туршлагад түшиглэн сонгосон ба үндсэн жор дээрээ нэг буюу хэдэн эм, эсвэл жорын найрлагаас хачирлан хэрэглэв. Хачир эмийг үндсэн жор болон тухайн анагаах өвчинтэй нь уялдуулан шинжлэхэд хорсны навч, шунх, хэл цоргигч давс, жуган, царван, пүрнаг, хүдрийн заар, 3 Халуун, луувангийн үнс зэрэг эмүүдийг үндсэн жорын чадлыг нэмэх зорилгоор, хорсны навч, жуган, царван, пүрнаг, хүдрийн заар, 3 Халуун, жуган дэжид, агар-8, гавал-3-ын тан зэрэг эмүүдийг өвчний шалтгаан, мөн чанарыг

дарах зорилгоор, шунх, хэл цоргигч давс, жуган дэжид, луувангийн үнс зэрэг эмүүдийг өвчний шинж тэмдгийг дарах зорилгоор тус тус хачирлав.

### 2. Жолоодлого эм (ᠵᠣᠯᠣᠣᠳᠯᠣᠭ᠎ᠠᠮ)

Жолоодлого эм нэмэрлэсэн жор 19 байна. Үүнд: Ад хавсарсан хий өвчнийг анагаахад задь, их мах, гүгэл 3-ыг гарьд-5 дээр нэмэрлэх, хан ад хавсарсан хий солиод гарьд-5 дээр задь, гүгэл нэмэрлэж хар гарьдын бясалгалаар амилуулан уулгах. Хүйтэн шард алтанцэцэг-3 дээр гарнаг, анар намэрлэх, мөн дэгд-8 дээр гарнаг, анар намэрлэх. Болман-7 дээр хий хаванд библин, агар, халуун хаванд жилжэ, тэмээн хөх, хүйтэн хаванд руда, даль, арьс махны завсрын хаванд жамба, үсү-г тус тус нэмэрлэх. Гиван, цагаан зандан, гүргэм, 3 үр, удбал, цагаан бон-а, башага, мэхээр, лидэр, дэгд дээр ходоодны нуугдсан халуунд алтанцэцэг, барагшун, зүрхний нуугдсан халуунд руда, агар, бойгар, бөөрний нуугдсан халуунд барагшун, хүдрийн заарыг нэмэрлэх. Зандан, гиван, гүрүэм, хорсны навч, дагша, цагаан бон-а дээр нян хижгийг амирлуулхад хар балчиргана, арилгахад тарныг нэмэрлэх. Зүрхний хийг дархад агар-8 дээр лиш, ажагсэржом, их махыг нэмэрлэх. Бадган ханиадад гантиг, бэрээмэг, үсү 3-ыг үзэм-7, жонж-7 дээр тус тус нэмэрлэх. Ходоодны өвчинд Үндэсны анарын найрлага<sup>5</sup> дээр бон-а, шудаг, руда, гарнагыг нэмэрлэх. Хүүхдийн хүйтэн өвчинд түшмэл-3 дээр даль нэмэрлэх. Эхэс түдхэд амар-6 дээр бөхөнгийн эвэр, туулайн хоргол нэмэрлэх зэрэг жорууд буй.

Жолоодлого эмийг задалж үзэхэд үндсэн эмийн чадлыг тухайн өвчний орон болон өвчний суурь буюу шалтгаан, мөн чанар, шинж тэмдгийг дархад удирдаж чиглүүлэх, мөн үндсэн эмийн чадлыг нэмэх зорилгоор нэмэрлэв. Тухайлбал зүрхэнд задь, лиш, ходоодонд анар, элгэнд гүргэмийг тус тус

орны үүднээс нэмэрлэсэн ба хийд задь, лиш, агар, шард жилжэ, тэмээн хөх, бадганд анар, даль, цусад гүргэм, шар усанд шар усны 3 эм, нянд бон-а, хүдрийн заар, гүгэл, хар балчиргана, хий цусанд мана, лиш, руда, хүйтэн шард анар, гарнаг, адад гүгэл, их мах, хатгалгаад ажагсэржом, хүдрийн заар, гүгэл, эхэс түдхэд бөхөнгийн эвэр, туулайн хоргол зэрэг эмүүдийг өвчний үүднээс үндсэн жорын найрлагатайгаа амт, чадлыг зохилдуулан тус тус нэмэрлэв.

### 3. Улируулах нэмэр (ᠠᠯᠢᠷᠠᠭᠤᠯᠠᠬᠤ)

Улируулах нэмэр тавьсан жор 8 байна. Үүнд: Няг, хий, халуун хавсарсан өвчинд агар-8 дээр норов-7-гийн тан, ажагсэржом, лиш, гүгэл, зэмбийг нэмэрлэх. Бөөрний өвчин, дусал цувирах, сахуу боомд гарьд-5 дээр хясаа, шунх, баавгайн цөс, гүргэм, гиван, хэл цоргигч давс, сүгмэл, 3 улаан нэмэрлэх. Толгойн халуунд гүргэм-13 дээр гавал-3-ын тан, ажагсэржом, хүдрийн заар, гүгэл нэмэрлэх. Эс шингэснээс үүссэн хаванд анар-5 дээр даль, төмрийн талх, бойгар, саармаг жамба, хавч, алтан элс нэмэрлэх. Уушгины халуунд эрхэм-8 дээр цагаан сороол, мэхээр, чихэр өвс, хүдрийн заар, гүгэл нэмэрлэх. Уушины өгөрд зандан-8 дээр чацаргана, руда, цагаан сира, зэсийн үнс, 3 эвэр нэмэрлэх. Халуун шар усны өвчинд лидэр, мана, сэндэн 3 дээр шар усны 3 эм, барагшун, арүр, гүргэм нэмэрлэх. Хижгийн халуун, гэдэсний хатгалгаад хар эм<sup>6</sup> дээр индра-4-ийн тан, хорсны навчийг тус тус нэмэрлэв.

Улируулах нэмэр эмийг үндсэн жор болон тухайн анагаах өвчинтэй нь холбон шинжилгээ хийж үзэхэд ерөнхий эмийн чадлыг тухайн өвчин буусан орны 3 гэмийн хямралыг арилгах, шинж тэмдгийг дарах, мөн үндсэн эмийн чадлыг дэмжих зорилгоор нэмэрлэв. Тухайлбал цул савны халууныг дарах чадал бүхий ерөнхий эм эрхэм-8 дээр уушгины халууныг дарах цагаан

сороол, мэхээр, ханиахыг зогсоож цэр ховхлох чихэр өвс, нянг нядлах заар, гүгэл зэрэг эмүүдийг нэмэрлэж улируулснаар уушгины халуун чанартай өвчийг анагаах чадал нь давамгайлсан болно. Хийг дарах агар-8 дээр халууныг дарах норов-7-гийн тан, нянг нядлах гүгэл, зимбэ, ажагсэржом, хийг дарах лиш зэрэг эмүүдийг нэмэрлэж улируулснаар хий, халуун, няг хавсарсан өвчийг анагаах чадал бүрдэв. Элэгний халууныг дарах гүргэм-13 дээр толгойн халууныг дарах гавал-3-ын тан, хатгалгааг дарах ажагсэржом, гүгэл, нянг нядлах хүдрийн заар зэрэг эмүүдийг нэмэрлэж улируулснаар толгойн халуун өвчнийг анагаах чадал бүрдэв. Галын илчийг үүсгэн эс шингэснийг шингээх анар-5 дээр хаванг анагаах даль, төмрийн талх, саармаг жамба, хавч, алтан элс, шар усыг хатаах бойгар зэрэг эмүүдийг нэмэрлэж улируулснаар эс шингэснээс үүссэн хаванг анагаах чадал бүрдэв. Уушгины халууныг дарах зандан-8 дээр уушгины халууныг дараж ходоодны илчийг сэлбэх цагаан сира, ханиахыг зогсоож цэр ховхлох чацаргана, руда, өгөрийг хатаах зэсийн үнс, 3 эвэр зэрэг эмүүдийг нэмэрлэж улируулснаар уушгины өгөрийг анагаах чадал бүрдэв. Лидэр, мана, сэндэн 3 дээр шар усыг хатаах шар усны 3 эм, халууныг дарах гүргэм, тэгшитгэх арүр, барагшун зэрэг эмүүдийг нэмэрлэж улируулснаар халуун шар усны өвчийг анагаах чадал бүрдэв. Хүйтэн шарыг дарах хар эм дээр гэдэсний халууныг дарах индра-4-ийн тан, нянг нядлах хорсны навч зэрэг эмүүдийг нэмэрлэж улируулснаар хижгийн халуун, гэдэсний хатгалгааг анагаах чадал бүрдэв. Гарьд-5 дээр бөөрний сайн сүгмэл, бөөрний гэмтсэн халууныг дарах 3 улаан, хаванг хөөх хэл цоргигч давс, цувирахыг зогсоох баавгайн цөс, гүргэм, халууныг дарах гиван, цал, цагаан судлын үйл ажиллагааг сайжруулах хясаа зэрэг эмүүдийг нэмэрлэж улируулснаар бөөрний өвчин, дусал цувирах,

сахуу, боомыг дарах чадал бүрдсэн болно.

#### 4. Хавсруулах нэмэр (ᠬᠠᠪᠰᠢᠷᠠᠭᠤᠯᠠᠬᠤ)

Хавсруулах нэмэр тавьсан жор 10 байна. Үүнд: Бөөрний нян халууныг дархад бөөрний арүр-10 дээр гарьд-5 хавсруулах, гүргэм-13 дээр гарьд-5 хавсруулах. Гэдэсний хатгалгааг дархад барагшун-9 дээр гарьд-5 хавсруулах. Зи ү (ᠵᠢᠦ)-3 дээр жонш, арүр, мана, барагшун, руда, цагаан бон-а, гиванг хавсруулснаар зи ү-10 болох ба халуун чанартай бор өвчнийг анагаах. Зи ү (ᠵᠢᠦ)-10 дээр шинца, жамцыг хавсруулснаар зи ү (ᠵᠢᠦ)-12 болох ба эмэгтэйн цус бүрэлдэж сарнисан өвчнийг анагаах. Гиван-9 дээр мана, үсү, жүрүр, бриянгу-г хавсруулснаар ланчэн-13 болох ба элэгний цус, борын халууныг анагаах. Улаан гаа-5 дээр гоюу, хэл цоргигч давсыг хавсруулснаар гоюу-7 болох ба бөөрний хүйтэн өвчнийг анагаах. Дэва (ᠳᠡᠪᠠ)-5 дээр банздоо, цагаан бон-а, цагаан танпром, хүдрийн заар, гүгэлийг хавсруулснаар дэва(ᠳᠡᠪᠠ)-10 болох ба унгарал өвчнийг анагаах. Агар-4 дээр шингүн, өмхий давсыг хавсруулснаар агар-6 болох ба зүрхний хий өвчнийг анагаах. Агар-8 дээр мана, лишийг хавсруулснаар бадра (ᠪᠠᠳᠢᠷᠠ)-10 болох ба хий цусаар хатгуулах, зүрхний өвчнийг анагаах зэрэг байна.

Хавсруулах нэмрийг шинжилж үзэхэд тухайн өвчний хавсарсан, хурсан гэмийг дарах зорилгоор үндсэн жор дээрээ өөр жор найрлагыг хавсруулан хэрэглэв. Мөн үндсэн жор дээрээ тухайн өвчинд чиглүүлэн тодорхой хэдэн эмүүдийг хавсруулан нэмэрлэж шинэ жорыг үүсгэн хэрэглэжээ.

#### Дүгнэлт

1. Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн “Увдист рашааны дусал” бүтээл дэх эм нэмэрлэж хэрэглэсэн 47 жорын нэмэр эмүүдийг хачир эм, жолоодлого эм, улируулах нэмэр, хавсруулах нэмэр

гэсэн 4 төрөлд ангилав.

2. Хачир эмийг мэргэдийн гүн увдис болон эмчийн туршлагад түшиглэн сонгов. Жолоодлого эмийг үндсэн жорын чадлыг өвчин буусан орон болон өвчний шалтгаан, мөн чанар, шинж тэмдгийг дархад чиглүүлэх зорилгоор, улируулах нэмэр эмийг ерөнхий эмийн чадлыг тухайн өвчин буусан оронруу чиглүүлж, тэрхүү орны 3 гэмийн хямралыг арилгах зорилгоор, хавсруулах нэмэр эмийг өвчний хавсарсан, хурсан гэмийг дарах зорилгоор тус тус нэмэрлэв.

#### Ном зүй

1. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх. 4 дүгээр боть. УБ, 2013
2. Болд Ш, Цэрэнсодном Д. Монголын уламжлалт анагаах ухааны тайлбарт дээж бичиг. УБ, Адмон принт, 2013. х. 162-284
3. Гарамчойнпил. བདེ་སྲོལ་གྱི་འཕྲུང་ས་དཔེ་ལེགས་བཤད་ རྩོམ་གྱི་སྒྲིལ་མཛེས། Төвөдийн ардын хэвлэлийн хороо, 1993. Х. 353
4. Чимэдрагчаа Ч, Дагвацэрэн Б нар. Уламжлалт эмт бодис, жорын хяналтын лавламж. УБ, 2015. х. 618
5. Анагаах ухааны дөрвөн үндэс. Орчуулсан Шин хэлин. Үндэстний хэвлэлийн хороо, 1991. х. 1632
6. Намжил. Монгол отчийн таван зохиол. ӨМШУТМХХ, 2014. х. 74

Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:  
МАУА-ийн гишүүн-Академич, профессор  
Ч.Чимэдрагчаа